

III. Монголын ойрхи түүхийн асуудлууд

1911 ОНЫ ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХУВЬСГАЛЫН ТҮҮХ БИЧЛЭГИЙН ҮЕЧЛЭЛ, АНГИЛЛЫН АСУУДАЛ

Б.Пунсалдулам

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

Өгүүллийн товч утга: 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхээр гарсан бүтээлүүдийг түүх бичлэгийн хувьд судлагдхуун болгон тавьж тодруулан судлахын тулд тодорхой цаг хугацааны хүрээнд авч, түүх бичлэгийн мэдээллийн объектив агуулга, субъектив хүчин зүйлсийг шалгуур үндэс болгон үечлэх асуудал гол байр суурийг эзэлнэ.

Түлхүүр үг: Хувьсгал, түүх бичлэг, үнэлэмж, үнэт зүйл, хүчин зүйл

1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүх бичлэгийн судалгаа болон танин мэдэхүүд түүний хөгжлийг үечлэх, ангилах асуудал тодорхой байр суурь эзэлдэг. 1911 оны Үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэг дэхь цэвэр үнэлэмжийн, үзэл суртлын, дадал заншлын, сүсэг бишрэлийн, цэвэр улс төрийн гэх мэт олон үзэл баримтлалуудыг системчлэн үечилж ангилах нь үр дүнтэй хөгжлийн нэгдмэл үзэл баримтлал боловсруулахад чухал байр эзэлдэг. Энэ асуудлыг шийдвэрлэхгүйгээр 1911 оны үндэсний хувьсгалын түүх бичлэгийн судалгааг иж бүрэн цогцолбор амжилттай болгох боломжгүй юм. Нөгөө талаар 1911 оны хувьсгалын түүх бичлэгийн хөгжлийг онолын түвшинд шинжилж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид хийх судалгааны ажлын чиглэл, зорилгоо тодорхойлох гол зорилт ч үүнийг шаардаж байдгаар тайлбарлаж болно.

Чухам үүнд л түүхийг судлахын зэрэгцээ түүхийн тухай түүхийн судалгаа буюу түүх бичлэгийн судалгаа явуулах мөн чанар оршино. Түүхийн шинжлэх ухааны цогцолбор иж бүрэн хөгжүүлэх нь түүх судлал, түүх бичлэгийн судалгааг хэр зэрэг хослон явуулж буй түвшингээр үнэлдэг билээ. Түүхийг үечлэх нь түүний үе тус бүрийн онцлог шинжүүдийг нээн гаргаж, танин мэдэж, түүгээрээ дамжуулан судлаж байгаа болон мэдэх гэж буй зүйлийн мөн чанарт нэвтрэн орох нэгэн боломжийг бүрдүүлдэг.

Энэ нь түүх бичлэгийн судалгаанд ч нэгэн адил хамаарах зүйл юм. Монголын түүх судлал дахь 1911 оны Үндэсний хувьсгалын түүх бичлэгийг үечлэх нь ямар нэгэн санаан зоргын хэрэг бус, харин судлагдахуун болж буй зүйлийн өөрийнх нь агуулга, мөн чанар болох зүй тогтолд тулгууралсан онолын удирдамж буюу шалгуур байх ёстой билээ. Шалгуур нь тухайн үзэгдэл, үйл явцын дотоод гол мөн чанарыг илэрхийлсэн байдгаас шалтгаалж аль нэг талыг голлон барих нь олонтоо байдаг.

Түүхийн шинжлэх ухаанд үечлэлийн асуудлыг нийгмийн хөгжлийн он дарааллын шатыг тогтоох гэсэн утгаар илүү давамгайл авч үздэг. Энэ шинж ч түүх бичлэгийн үечлэлд агуулагдаж байдаг. Тухайлбал Монгол улсын түүх / онол арга зүйн асуудлууд/ номонд Монголын түүхийн шинжлэх ухааны хөгжлийг эртний үе, дундад үе, ойрхи үе гэж гурван үед хувааж үзээд эртний үед Монгол угсааны овог аймаг улсуудын түүхийг судлаж эхэлсэн тэр цагаас МЭ VII–IX зууны, дунд үе нь VII–IX аас XX зууны эхэн үе, ойрхи үе нь XX зуунаас хойшхи өнөөг хүртлэх үеийг хамруулжээ.¹ Дээрхи үечлэлээр ойрхи үед хамрагдаж байгаа 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүх бичлэгийг судлагдхуун болгон тавихад ямар шалгуураар, юуг хэрхэн үечлэх тухайгаа тодруулах шаардлага гарч байна.

¹ Монгол улсын түүх /Онол арга зүйн асуудал/ УБ.,1999,т.14

Түүх бичлэг бол түүх судлалын үр дагавар бөгөөд түүний бүтээгдхүүн. Тиймээс түүх бичлэг түүх судлал хоёр дотоод уяалдаа холбоотой нэг зоосны хоёр тал мэт үйл ажиллагаа, өөрөөр хэлбэл, түүх бичлэг нь түүх судлалын тольдсон тусгал мөн.² Түүх бичлэг түүхийн шинжлэх ухааны түвшний үзүүлэлт болдог гэсэн батламжууд дээр тогтож, 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхээр гарсан түүх судлалын бүтээлүүдийг зохих шалгуурын дагуу он дарааллын шатыг тогтоох хэмээн ойлгож болох юм. Гэхдээ түүх бичлэгийг болж өнгөрсөн үйл явдлуудын он цагийн дараалал, зураглал мэт үзэж хэт өрөөсгөл ойлгож болохгүй.

Энд цаг хугацааны хүчин зүйлээс гадна эрхэмлэл үнэлэмжийн өөрчлөлт түүх бичлэгт ямагт нөлөөлж байсныг тооцож тодруулахыг хүсэж байна. Өөрөөр хэлбэл түүх бичлэгийг үечлэх зохих шалгуур нь объектив, субъектив хоёр хүчин зүйлээс хамааралтай юм.

Объектив гэсэн ойлголтод тухайн түүхээр гаргасан судалгааны бүтээлийн цаг үе, нийгмийн орчин, гадаад дотоод түүхэн тодорхой нөхцөл байдал, тэр үеийн онцлог, соёлын эрхэмлэл үнэлэмжүүд гэх мэт уг түүх судлалд зайлшгүй нөлөөлөх хүчин зүйлийг ойлгож байгаа юм.

Харин субъектив нь зохиолчийн үзэл бодол, боловсрол, ашиг сонирхол, зан чанар нийгэмд эзлэх байр суурь гэх мэт түүх бичлэгт нөлөөлж болох талуудыг хамруулан үзээд Монголын түүх судлал дахь 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхийн түүх бичлэгийг

А/ ХХ зууны эхний хагасын Цагаагчин гахай жилийн хувьсгалын түүхийн түүх бичлэг (1911-1950 он)

Б/ Марксист түүх бичлэг дэхь 1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн (1950-1990 он)

В/ Түүх судлалын шинэчлэлийн үеийн Үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэг хэмээн гурван үед үечлэж болох юм хэмээн үзэж байна.

Монголын түүх судлал дахь 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхийн түүх бичлэгийн судалгаа явуулна гэдэг нь 1911 оны хувьсгалын түүхээр гарсан судалгааны бүтээлүүдийг судлагдхуун болгон авч үзнэ гэсэн хэрэг мөн. Үүний тулд 1911 оны үндэсний хувьсгалын түүхээр гарсан түүх судлалын бүтээлүүдийг чухамхүү бүтээл болгоход хүргэсэн тэр хүчин зүйл / объектив, субъектив/, үе бүхнийг тэдгээрийн харилцан үйлчлэлд тооцож авч үзэх хэрэгтэй болдог.

Тэргүүн хэсэг буюу ХХ зууны эхний хагасын Цагаагчин гахай жилийн хувьсгалын түүхийн түүх бичлэгийг

Нэгд: 1911 оны үндэсний хувьсгалын түүхийн бүтээлүүдийг дотор нь бичлэгийн хэлбэр, агуулгаар нь а/ Тогтмол хэвлэл, б/ Судалгааны буюу дурсамж, дуртгалын бүтээлүүд,

Хоёрт: Судалгааны буюу дурсамж, дуртгалын бүтээлүүдээ хэвлэгдэн гарсан он цаг, үнэлэмжээр нь а/ 1911-1930 аад оны Монголын түүхчдийн бүтээлд Цагаагчин гахай жилийн хувьсгалын түүхийг авч үзсэн нь, б/ 1930-аад оноос-1950 оны түүх судлал дахь эрх чөлөөний хувьсгал хэмээн ангилан авч үзэж байна.

1911 оноос- 1930-аад он хүртэлхи үеийн түүхийн бүтээлүүд нь бичлэг хэлбэрийн хувьд уламжлалт чиглэлийг түлхүү баримталсан, нөгөө талаар хориод оны үеийн төр, намын бодлого, монголын ард түмний түүхэн замналыг сурталчлахад чиглэгдсэн энгийн хэллэгтэй, дурсамж, дурдтгалын шинжтэй байв.

Харин 1930-аад оноос –1950 оны үед Монголын 1911 оны Үндэсний хувьсгалын түүхийг марксист ёсоор үнэлэн судлах ажлын эхлэл тавигдаж анхны бүтээл нь Цэрэн – Очирын “Автоном Монгол” хэмээх товхимол гарч, цаашид улмаар төр намын захиа даалгавраар түүх бичих бүтээх ажил хийгджээ. Гучаад оны дунд үед түүхийн салбарт

² Л.Мөнх-Эрдэнэ. Түүхийн гүн ухааны лекцүүд. УБ., 1999, т.31

нам төрийн зүтгэлтнүүд ард түмнийхээ түүхийг судлан боловсруулах ажилд зохих хувь нэмэрээ оруулж байв. Тухайлбал А.Амар/Ерөнхий сайдын ажлыг хашиж байв/, Н.Магсаржав/ Ардын засгийн шүүх яамны анхны тэргүүн сайд /, Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нарыг дурдаж болох юм.

1930-аад оны үеэс олон улсын байдал хурцдаж, улмаар дэлхийн хоёр дугаар дайны хүнд үед түүх судлалын гол чиглэл ард түмнийг хувьсгалч, эх оронч, ахмад үеийн дайчин баатарлаг тэмцлийн түүхээр хүмүүжүүлэхэд чиглэгдсэнтэй холбоотойгоор бидний сонирхож буй үе буюу 1911 оны Үндэсний хувьсгалын удирдагчдын түүхэнд холбогдох бүтээлүүд гарчээ.

1911 оноос –1950 оны түүх бичлэгийн гол үндсэн шинж нь Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолдоо хүрэхийн тулд баримтлаж байсан үнэлэмж, зарчмуудыг эрхэм байдлаар илэрхийлж байсанд оршино.

Энэ үед Манжийн төрийн хятадчилан уусгах бодлого улам хүчтэй болж, Монгол улсынхаа хувь заяаны төлөө санаа зовинодог хэн бүхний өмнө улс орныхоо тусгаар тогтнолыг авран хамгаалахын тулд хэрхэн тэмцэх тухай асуудал тулгарч, үндэсний эрх чөлөөний төлөө үзэл санаа нийгмийн сэтгэлгээнд давамгайлж байсан үе юм. Өөрөөр хэлбэл, энэ үеийн түүх бичлэгийн нийгмийн үзэл санааны гол цөм нь үндэсний ардчилсан үзэл байв.

XX зууны эхний хагасын үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэгийн оргил нь Л.Дэндэвийн “Монголын товч түүх”¹, Н.Магсар хурцын “Монгол улсын шинэ түүх”² зэрэг бүтээлүүд юм. Энэ үеийн түүх бичлэгийн бүтээлүүд нь үндэсний хувьсгалын үйл явдал болсон цаг хугацаанд хамт бичигдсэн /”Шинэ толь” сэтгүүл дээрхи үндэсний хувьсгалын тухай өгүүлэлүүд Б.П/ нөгөө талаар мөн үеийн хүмүүс/ хувьсгалд оролцож байсан, нүдээр үзэж харсан/ хэрхэн ойлгож, хүлээн авч байгаагаа тусгадаг тул 1911 оны хувьсгалын түүхийг тухайн үеийн оюун санаагаар ойлгоход чухал баримт болдог учир ерөнхийдөө эх сурвалжийн шинжийг агуулж байдгаараа бусад түүх бичлэгийн үеүүдээсээ ялгагддаг.

Хоёр дахь үе буюу марксист түүх бичлэг дэхь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хэмээн үечилсэн объектив, субъектив нөхцлөө МАХН-ын X хурлаас баталсан намын программд БНМАУ “Нийгэм журамд орох явцыг бэлтгэх” буюу сүүлд тодруулан томъёолдог болсноор тус оронд социализмын үндэс байгуулах зорилт дэвшүүлсэн үеэс эхлүүлж улмаар 1960 он гэхэд нийгмийн өмч үйлдвэрлэлийн харилцаанд ялсан, 1960 оноос хойш социализмын бүрэн ялалтыг хангах үйл явц хэмээн ойлгож ирсэн цаг үеэр

а/ 1950-1960-аад оны үеийн Монголын түүх судлал дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн

б/ 1960-аад оноос-1990 он хүртлэх үеийн 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүхийн түүх бичлэг хэмээн ангилж байна. Гэхдээ ингэж ангилахад зөвхөн дээрхи үндэслэл хангалтгүй нь ойлгомжтой юм.

Үүнд 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын гарах болсон урьдач нөхцөл, шалтгаан, гадаад, дотоод хүчин зүйл, хувьсгалын зорилго, шинж чанар, хөдөлгөгч хүч, удирдагчид, ач холбогдол зэрэг судалгааны олон чухал асуудлыг хэрхэн үнэлж дүгнэж ирсэн эрдэмтдийн судалгаа үзэл баримтлалыг харгалзан үзсэн билээ. Өөрөөр хэлбэл түүх бичлэгийн өөрийнх нь шинж төрхөд үндэслэсэн билээ. Нөгөө талаар 1940 оны сүүлч 1950 оны эхээр Монголд түүхийн мэргэжлийн боловсон хүчнүүд бэлтгэгдэж, 1950 –1961 оны хооронд түүхийн ухаанаар эрдмийн зэргийг нилээд олон эрдэмтэн судлаачид хамгаалж, түүх судлал жинхэнэ утгаараа / шинжлэх

¹ Л.Дэндэв. Монгол улсын товч түүх. УБ.,1934

² Н.Магсаржав. Монгол улсын шинэ түүх.УБ.,1994

ухааны зэргэмжинд хүрсэн/ хөгжсөн Монголын түүх судлалын түвшинг ч харгалзан тооцсон билээ.

1954 онд хуралдсан МАХН-ын XII их хурал үзэл суртлын ажлыг социалист байгуулалтын шинэ зорилтын хэмжээнд хүртэл дэвшүүлэхийг зааж, намын түүхийн сурах бичиг зохиож гаргах намын үзэл суртлын ажлын чухал зорилтын нэг болгож тавьсан нь бидний өгүүлэн буй үндэсний хувьсгалын түүх судлалыг тойрч гараагүй юм. Энэ үеийн түүх судлалын талаар гарсан том ололтын нэг бол монгол, зөвлөлтийн түүхчдийн хамтын бүтээл "БНМАУ-ын түүх" нэгэн боть зохиол¹, Ц.Пуицагноровын "Монголын Автономитийн үеийн түүх"² зэрэг марксист-ленинист онол арга зүйгээр бичигдсэн бүтээлүүд юм.

Хэрэв өмнөх үед марксист-ленинизмын онол сургаал түүхийн судалгааны бүтээлд эхлэл төдий ажиглагдаж байсан бол өгүүлэн буй үед судалгааны ажлын онолын удирдамж ажлын арга барил нь болсон байна.

Энэ үеийн 1911 оны үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэгийн бүтээлүүд үзэл суртлын хальс бүрхэвчин доор анги намын байр суурьнаас үнэлж дүгнэж байсан нь үнэн боловч чухам энэ үед гаргасан бүтээлүүдийн ачаар л 1911 оны үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэгийн судалгааг явуулах буюу судлагдхуун болгон тавих боломж бүрдсэн юм. Өөрөөр хэлбэл, 1911 оны үндэсний хувьсгалын түүхээр судалгааны дорвитой бүтээлүүд энэ үед гарсныг мартаж үнэ цэнийг бууруулж болохгүй билээ.

Гурав дахь үе буюу түүх судлалын шинэчлэлийн үеийн 1911 оны Үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэг хэмээн үечилсэн обьектив, субъектив нөхцлөө 90-ээд оноос Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэн, нийгмийн судалгаанд олон ургалч үзлийн зарчим нэвтэрсэнтэй холбон үзэж байна.

Түүхийн судалгаанд олон ургалч үзлийн зарчим нэвтэрснээр түүх судлал дахь 1911 оны үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэгийн судалгаа шинэ шаганд гарч олон арван бүтээлүүд хэвлэгдэн гарч байна.

Тийм учраас түүх судлалын шинэчлэлийн үеийн 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхийн бүтээлүүдийг судлагдхуун болгохдоо хувьсгалын түүхийн судалгааг хөндсөн сэдэв, тулгамдсан асуудлыг хэрхэн авч үзэж тайлбарлаж байгаагаар нь

А/ Хувьсгалын үр дүн, ач холбогдол, хувь заяаны тухай судалгаа

Б/ Хувьсгалын хөдлөгч хүч, удирдагчдын тухай судалгаа

В/ Монголын хувьсгалуудын уялдаа холбоо, залгамж чанарын тухай судалгаа гэх мэтээр сэдэвчлэн ангилж болох юм хэмээн үзэж байна.

Мөн Монголын түүх судлал дахь 1911 оны Үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэгийн бүх бүтээлүүдийг тухайн үеийн үнэлэмжээр нь үзэл суртлын, дадал заншлын, сүсэг бишрэлийн, улс төрийн, цэвэр үнэлэмжийн хэмээн ангилж болох юм.

1990 оноос хойшхи үеийн түүх бичлэгийн үндсэн шинж нь олон ургалч үзлээ дээдлэж, сэтгэлгээний нэг хэв загварт баригдахаас зайлсхийж түүхэн үнэнийг тайлбарлах олон аргыг эрэлхийлж байгаад оршино.

1990 оноос өмнөх 1911 оны Үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэгт эрх чөлөөний хувьсгалын түүхийн нийтлэг шинж, гарах болсон шалтгаан, гадаад дотоод нөхцөл, хөдөлгөгч хүч, зайлшгүй зүй тогтолтыг танин мэдэхэд анхаарлаа чиглүүлж байсан бол, 1990 оноос хойшхи түүх бичлэгт хувьсгалын өвөрмөц, давдагдашгүй, санамсаргүй тал шинжийг танин мэдэхэд анхаарлаа төвлөрүүлж байна.

¹ БНМАУ-ын түүх нэгэн боть. УБ., 1954

² Ц.Пуицагноров. Монголын автономитийн үеийн түүх. УБ., 1955

1990 оноос XX зууны Монголын түүхийн олон асуудлыг үнэн мөнөөр нь бичих, үзэл суртлын хальс бүрхэвчнээс нь салгаж ойлгох эрмэлзлэл судлаач эрдэмдэт, түүх сонирхогчдын дотор мэдэгдэм ахицтай байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Мөн улс төрч, нийтлэгч, сэтгүүлчид Монголын ойрхи түүхийн асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлсэн ном бичих боллоо. Үүнээс хамгийн томоохон нь Б.Баабарын бичсэн “XX зууны Монгол: нүүдэл, суудал, гарз, олз” хэмээх бүтээл юм.¹ Энэ ном нь хатуу хараа хяналттай, бичлэгийн тогтсон хэв загвараар бичигдсэн ном бүтээлд дассан уншигчдыг эгэл бус үг хэллэг, этгээд сонин содон өвөрмөгц онцгой найруулгаар амьдлаг болгож, түүхийг шинээр харснаараа анхаарал татаж чадсан юм. Эдгээр хүмүүсийн бичсэн ном өгүүлэлд түүх бичлэгийн асуудалд арай өөрөөр хандаж түүхэн утга зүйн хувьд зүйн хувьд олны анхаарлыг татахуйц шинэлэг аяс ажиглагдаж байгаа боловч, учиг баримтыг нарийн судлалгүй сэтгэлийн хөөрөлд автаж, улс төрийн үзэл бодолдоо тохируулан хэт туйлширсан өрөөсгөл ташимгай дүгнэлт хийж байгаа нь олон түмэнд түүхийн зөв ухамсар суулгахад таагүй нөлөө үзүүлж байна.

Оросын нэрт эрдэмтэн Н.Бердяев: “Өнгөрсөн түүхээ хайрлдадаггүй, түүнийг цоо шинээр эхлэх гэж хүсдэг ард түмэн бол золгүй ард түмэн” гэж тэмдэглэжээ. Иймээс бид түүхийн сургалт, судалгаа явуулахдаа өнгөрсөн үеийн асуудалд түүхэн зүхлийн үүднээс биш, түүхэн ухаарал, сургамжийн үүднээс хандвал зохилтой. Түүхийн үйл явцыг улс төрүүлж, эдүгээчлэн хандах тусам алдах нь их байх болно. Ийм хандлага үнэн зөв байр суурин дээр зогсож, Монголын түүхчдийн судалгаа хийх зөв ухамсар төлөвшихөд туйлын хортой нөлөө үзүүлэх болно гэжээ.

1990 оноос хойш Монголын түүх судлалд гарсан нэг гол ололт бол энэ зууны гарамгай улс төрийн зүтгэлтнүүдийн намтар судлал илүү ахицтай хөгжиж байгаа явдал юм. Намтар судлал бол түүхэн хүн судлалын тулгуур мөн. Энэ салбар хөгжсөнөөр түүхийг эзэнгүйдүүлэх явдлыг даван туулж, түүхийг бичлэгт ахиц гарах нэг үндэс бүрдэх юм. Бас нэг ололт бол урьд өмнө судалгааны эргэлтэд төдийлөн ороогүй эх сурвалж, архивын баримт бичгийн эмхтгэл бэлтгэн хэвлүүлж байгаа нь 1911 оны Үндэсний хувьсгалын түүхийн түүх бичлэгийн судалгаанд чухал ач холбогдолтой билээ.

Abstract:

The objective content and subjective factors in historiography as main categories for classification as historiographical subject of studies works of scholars about the National Liberalization Revolution of 1911 should be classified in chronologically.

This is attempt to classify works of Mongolian scholars about the National Liberation Revolution of 1911 in Mongolian historiography.

1. Historiography of Revolution of White Boar Year at the first half of XX century (1911-1950)

2. The National Liberalization Movement in Marxist historiography. (1950-1990)
Historical studies of National Liberalization Revolution in reformation period.

Ном зүй

1. Батбаяр.Б XX зууны Монголын нүүдэл, суудал, гарз, олз.УБ.,1996
2. БНМАУ-ын түүх нэгэн боть.УБ.,1954
3. Болдбаатар.Ж Түүх зулсан он жилүүдийн ойллого. УБ.,2003
4. Дэндэв.Л Монгол улсын говч түүх. УБ.,1934
5. Магсаржав.Н Монгол улсын шинэ түүх.УБ., 1994
6. Монгол улсын түүх /Онол арга зүйн асуудал/ УБ.,1999
7. Мөнхэрдэнэ.Н Түүхийн гүн ухааны лекцүүд. УБ.,1999
8. Пунцагноров.Ц Монголын автономитийн үеийн түүх. УБ.,1955
9. Түүхийн судалгааны онол арга зүйн асуудлууд . УБ.,1999

¹ Б.Батбаяр XX зууны Монголын нүүдэл, суудал,гарз,олз.УБ.,1996

² Ж.Болдбаатар. Түүх зулсан он жилүүдийн ойллого.УБ.,2003,т,48